



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 05 сарын 22 өдөр

Дугаар 40

Алтай

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14 дэх заалт, Сонгуулийн Ерөнхий хорооны 2017 оны 19 дүгээр тогтоолыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2013 оны ээлжит сонгуулийн хадгалах хугацаа дуусгавар болсон саналын хуудсыг устгах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: А.Мөнхтөр /ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч/

Гишүүд: Д.Баттайван /ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга/
Ж.Наранбаатар /Аймгийн Цагдаагийн газрын дэд дарга, Цагдаагийн хошууч/

Д.Энхбат /Аймгийн Тагнуулын хэлтсийн ажилтан/

М.Мандаххүү /ЗДТГ-ын Архивын тасгийн дарга/

2. Хууль тогтоомжид заасны дагуу саналын хуудсыг устгах ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, Саналын хуудас устгасан тухай тэмдэглэлийн хувийг Сонгуулийн Ерөнхий хороонд хүргүүлэхийг ажлын хэсгийн дарга /А.Мөнхтөр/-д даалгасугай.

ДАРГА  Т.ГАНЗОРИГ